



240

## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 1/326

Булган

### Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.2.1, Хог хаягдлын тухай хуулийн 9.3.1, 9.3.4 дэх заалт, аймгийн ИТХ-ын 2017 оны VI хуралдааны 06/06 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын хог ангилан ялгах сурталчилгааны материал, гарын авлага хэвлүүлэх зардлыг нэгдүгээр, хэсгийн ахлагч, багийн иргэдэд хог ангилан ялгах сургалтын зардал болон болзолт уралдааны зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Дээрх ажлыг чанартай сайн зохион байгуулж ажиллахыг Булган сумын Засаг дарга /Д.Наранбаяр/, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /А.Гантөмөр/ нарт тус тус даалгасугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 13 350 000 /арван гурван сая гурван зуун тавин мянга/ төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

Аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 03 ны өдрийн 448 дугаар захирамжийн ... дүгээр хавсралт

Хог ангилан ялгах сурталчилгааны материал, гарын авлага хэвлүүлэх зардал

Д/Д	Тараах материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ/төг/	Нийт үнэ /төг/	Тайлбар
1	Хог хаягдлын тухай бяцхан ном	ш	500	2700	1350000	Хуулийн шинэчилсэн найруулгын хураангуй, хог хаягдлаа хэрхэн ангилан ялгах, хог хаягдлын нас, байгальд үзүүлэх сөрөг нөлөө, жорлонгоо өөрчилье гэх мэт
2	Хог хаягдлаа хэрхэн ангилан ялгах вэ? гарын авлага /А-4 хэмжээтэй/	ш	2500	1400	3500000	Булган сумын гэр хорооллын айл өрхүүдэд
3	Хог хаягдлын нас, байгальд үзүүлэх сөрөг нөлөө	ш	2500	1400	3500000	Булган сумын гэр хорооллын айл өрхүүдэд
4	Хог хаягдлын нас	ш	1000	1400	1400000	Байгууллага, сургууль цэцэрлэгт
5	Хогоо ангилан хаяцгаая	ш	1000	350	350000	Байгууллагуудад наалт
6	Хог хаягдлыг ангилан ялгах талаар мэдээллийн хэрэгсэл, цахимаар хийх сурталчилгааны зардал	1 мин	4 сар	100000	400000	"Сайхан Монгол" зурагтаар видео зар сурталчилгааг 6-9 сард явуулах
Нийт					10500000	

042

Аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар  
сарын 23 -ны өдрийн 426 дугаар  
захирамжийн ... дугаар хавсралт

Хэсгийн ахлагч, багийн иргэдэд хог ангилан ялгах  
сургалтын зардал

	Арга хэмжээний нэр	Оролцох хүний тоо	Зардлын нэр	Хэмжих нэгж	нэгжийн үнэ /төг/	Нийт зардал /төг/
1	Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, хог хаягдлыг ангилан ялгах талаар сургалт хийх 1	100	Завсарлагааны цай	1/100	1,500	150,000
2	Хэсгийн ахлагч, багийн иргэдэд хог ангилан ялгах сургалтыг зохион байгуулах	300	Торны үнэ	1 багт 50-аас доошгүй	3,000	900,000
3	Цэцэрлэг, сурагчдад "Хог бол баялаг" сургалтыг зохион байгуулах /1,2 дугаар цэцэрлэг, 1,2,3 дугаар бүрэн дунд сургууль/	300				
Нийт						1050000

Болзолт уралдааны зардал

№	Үйл ажиллагаа	Зардлын нэр	Нэг бүрийн үнэ /Төг/	Нийт үнэ /Төг/
1	"Хоггүй цэвэр хэсэг" болзолт уралдааны шагнал	1-р байр	300000	600000
		2-р байр	200000	
		3-р байр	100000	
2	"Байгальд ээлтэй хамт олон" болзолт уралдааны шагнал	1-р байр	500000	900000
		2-р байр	300000	
		3-р байр	100000	
3	Өргөмжлөл	6 ширхэг	50000	300000
Нийт				1800000